



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ
ГАЗАР

Нийслэлийн засаг захиргааны IV байр,
4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, 15160-0066
Утас:(976) 7575 7807, Факс: (976) 7575 7809
Цахим шуудан: contact@ub-procurement.mn
Цахим хаяг: www.ub-procurement.mn

2024.02.20 № 03/212

танай _____-ны № _____-т

Тодруулгын хариу хүргүүлэх тухай

Тус газраас зарласан НХААГ/20240103147 дугаартай "Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө"-г боловсруулах зөвлөх үйлчилгээний ажилд тендерт оролцохыг сонирхогч этгээдээс цахим системээр дараах тодруулгыг ирүүлсэн байна. Үүнд:

№	Оролцогчоос ирүүлсэн тодруулга	Тодруулгын хариу
1	ТШЗ 19.1.2-т Сүүлийн 3 жил буюу 2020, 2021, 2022 онуудын аль нэг жилд батлагдсан төсөвт өртгийн үнийн дүнгийн 60 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлын үндсэн гүйцэтгэгчээр хоёроос доошгүй удаа ажилласан байна... гэж заасан байна. Төсөвт өртгийн 60% нь 3,120,000,000 (гурван тэрбум нэг зуун хорин сая төгрөг). Тэгэхээр нийлээд 6,240,000,000-с багагүй үнийн дүнтэй 2 ажил гэсэн үгүү? Эсвэл аль нэг онд гүйцэтгэсэн 2-с дээш олон ажил нийлээд төсөвт өртгийн 60% буюу 3,120,000,000-с дээш юмуу?	ТШЗ 19.1.2-т Сүүлийн 3 жил буюу 2020, 2021, 2022 онуудын аль нэг жилд батлагдсан төсөвт өртгийн үнийн дүнгийн 60 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлын үндсэн гүйцэтгэгчээр хоёроос доошгүй удаа ажилласан байна... гэж заасан. Энэ нь тухайн 2020, 2021, 2022 онуудын аль нэг жилд 2 гэрээ нь тус бүр төсөвт өртгийн 60 хувиас багагүй байна.
2	Түншлэлийн хэлбэрээр оролцож болох уу?	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д тендер шалгаруулалтад аж ахуй эрхлэгч дангаараа эсхүл түншлэлээр тендер ирүүлж болно гэж заасан байх тул оролцож болно.

Тендер шалгаруулалтын зааврын 9.4-т Захиалагч тодруулга авах хүсэлтийн хариуг албан бичгээр үйлдэж, цахим системд нийтэлснээр хүргүүлсэн гэж тооцно. Тендер шалгаруулалтын заавартай сайтар танилцаж, тендерт оролцохыг хүсье.